



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 05 сарын 05 өдөр

Дугаар 174

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1, “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээ”-ний тухай Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1.а дахь заалт, Говь-Алтай аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2020 оны 04 дүгээр тогтоол, 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Говь-Алтай аймгийн орон нутгийн өмчөөс төрийн өмчид шилжүүлсэн нийт 9 нэрийн 865,226,420.00 (найман зуун жаран таван сая хоёр зуун хорин зургаан мянга дөрвөн зуун хорин) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг төрийн өмчид хүлээн авч, “Алтай-Улиастайн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанид эзэмшүүлсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Батгэрэл, “Алтай-Улиастайн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захидал А.Пүрэвсүрэн, Говь-Алтай аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Л.Ганхуяг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

3.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.НАРАНГЭРЭЛ

900286

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын
 2020 оны 07 дугаар сарын 05ны өдрийн
 77 дугаар тогтолцын хавсралт
**"АЛТАЙ-УЛИАСТАЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААЛТЫН
ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

д/д	Ажлын нэр	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Нийт үнэ /төгрөг/
1	Бигэр сумын Өөш багийн нутаг дэд станц, ЦДАШ-ийн ажил	35/0.4квт-ын 63ква дэд станц	2013	27,000,000.00
2	Шарга сумын гүүр орчмын айл өрхийг цахилгаанаар хангах дэд станц ЦДАШ-ын шинэчлэл	15/0.4квт 63ква дэд станц	2013	28,000,000.00
3	Алтай хотын төвд дэд станц 4500 м 6 квтын ЦДАШ, 6/0.4 квт-ын 5ш дэд станцын ажил	6/0.4квт-ын 160ква дэд станц	2013	275,000,000.00
4	Алтай сумын нарны станцыг өргөтгөх ажил	150квт станц, нарны цахилгаан станцын 640 ширхэг толь, 240 ширхэг батерий	2015	100,000,000.00
5	Алтай сумын НЦС-д өргөтгөл	Нарны цахилгаан станц 70 ширхэг толь	2016	170,000,000.00
6	Дэлгэр сумын 4.5км ЦДАШ	35/0.4квт-ын 63ква дэд станц	2019	71,930,000.00
7	Тонхил сумын Алтансоёмбо багийн	30квт-ын нарны эх уусвэр	2018	111,296,420.00
8	Төгрөг сумын 0.4 квт-ын ЦДАШ-ын ажил	6/0.4квт-ын 160ква дэд станц	2019	42,000,000.00
9	Жаргалан сумын ЦДАШ-ын өргөтгөл	Жаргалан сумын ЦДАШ-ын өргөтгөл	2019	40,000,000.00
				865,226,420.00
				(Найман зуун жаран таван сая хоёр зуун хорин зургаан мянга дөрвөн зуун хорин)

НИЙТ ДҮН